



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Жаргалант сумын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2022/68/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Эрдэнэт хот
2022 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Эрдэнэ
Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn
Аудитор: Б.Азжаргал
Утас: 70350757 Цахим хаяг: azjargalb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт.....	15
4.1 Залруулсан алдаа	15
4.4 Зөвлөмж	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

САНАЛ ДҮГНЭЛТ



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826

Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.07.28 № 67

танай _____-ны № _____-т

ЖАРГАЛАНТ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Д.НЯМДАВАА ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Жаргалант сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Жаргалант сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

D:\my doc \alban bichig\ 2022-A4.doc


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Дансны код	Балансын үзүүлэлт	Эцсийн үлдэгдэл аудитлагдаагүй	Эцсийн үлдэгдэл аудитлагдсан
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	132,859,316.66	132,859,316.66
33	АВЛАГА	4,300,000.00	4,300,000.00
3351	Байгууллагаас авах авлага	4,300,000.00	4,300,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	128,559,316.66	128,559,316.66
351	Түүхий эд материал	127,950,316.66	127,950,316.66
35110	Тусгай зориулалттай материал	127,950,316.66	127950316.7
354	Хангамжийн материал	609,000.00	609,000.00
35420	Аж ахуйн материал	609,000.00	609,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,942,160,443.77	2,942,160,443.77
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,942,160,443.77	2,942,160,443.77
392	Биет хөрөнгө	2,904,252,443.77	2,904,252,443.77
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,747,675,370.19	2,747,675,370.19
39202	Хуримтлагдсан элэгдэл	(188,845,763.60)	(188,845,763.60)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	200,057,307.42	200,057,307.42
39206	Хуримтлагдсан элэгдэл	(115,984,858.45)	(115,984,858.45)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	283,366,068.70	283,366,068.70
39208	Хуримтлагдсан элэгдэл	(141,195,087.24)	(141,195,087.24)
39214	Бусад үндсэн хөрөнгө	155,086,839.68	155,086,839.68
39215	Хуримтлагдсан элэгдэл	(35,907,432.93)	(35,907,432.93)
393	Биет бус хөрөнгө	37,908,000.00	37,908,000.00
39301	Програм хангамж	250,000.00	250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(250,000.00)	(250,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	37,908,000.00	37,908,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,075,019,760.43	3,075,019,760.43
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,075,019,760.43	3,075,019,760.43
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	595,526,061.12	595,526,061.12
	Дахин үнэлгээний нөөц	1,558,525,345.86	1,558,525,345.86
512	Хуримтлагдсан үр дүн	920,968,353.45	920,968,353.45
51210	Өмнөх үеийн үр дүн	1,118,351,066.16	1,118,351,066.16
51220	Тайлант үеийн үр дүн	(197,382,712.71)	(197,382,712.71)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,075,019,760.43	3,075,019,760.43

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Аудитлагдаагүй	Аудитлагдсан
		Тайлант оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,179,276,474.55	1,169,652,561.55
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	35,876,107.00	35,876,107.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	35,876,107.00	35,876,107.00

Жаргалант сумын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,108,454.55	6,108,454.55
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	700,000.00	700,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,035,254.55	5,035,254.55
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	373,200.00	373,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	176,077,700.00	176,077,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	176,077,700.00	176,077,700.00
1330	Төсвийн захирагчдаас	951,590,300.00	951,590,300.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	951,590,300.00	951,590,300.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	9,623,913.00	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	9,623,913.00	-
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,302,970,619.43	1,293,346,706.43
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,302,970,619.43	1,293,346,706.43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	752,253,844.22	752,253,844.22
210101	Үндсэн цалин	475,461,792.25	475,461,792.25
210102	Нэмэгдэл	233,597,564.68	233,597,564.68
210104	Урамшуулал	43,194,487.29	43,194,487.29
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	97,240,603.15	97,240,603.15
210201	Тэтгэврийн даатгал	66,155,511.10	66,155,511.10
210202	Тэтгэмжийн даатгал	7,771,273.01	7,771,273.01
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,217,018.41	6,217,018.41
210204	Ажилгүйдлийн даатгал	1,554,254.60	1,554,254.60
210205	Эрүүл мэндийн даатгал	15,542,546.03	15,542,546.03
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	166,518,256.70	166,518,256.70
210301	Гэрэл, цахилгаан	9,752,633.95	9,752,633.95
210302	Түлш, халаалт	152,773,632.00	152,773,632.00
210303	Цэвэр, бохир ус	3,991,990.75	3,991,990.75
2104	Хангамж, бараа материалын зардал	14,472,400.00	14,472,400.00
210401	Бичиг хэрэг	1,985,500.00	1,985,500.00
210402	Тээвэр, шатахуун	6,796,000.00	6,796,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	236,900.00	236,900.00
210404	Ном, хэвлэл	636,800.00	636,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,788,500.00	1,788,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,028,700.00	3,028,700.00
2105	Нормативт зардал	28,383,000.00	28,383,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	376,400.00	376,400.00
210502	Хоол, хүнс	27,160,600.00	27,160,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	846,000.00	846,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,126,681.00	10,126,681.00
210604	Урсгал засвар	10,126,681.00	10,126,681.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,900,000.00	1,900,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,900,000.00	1,900,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	167,089,602.05	167,089,602.05
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	700,000.00	700,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,519,400.00	9,519,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	156,870,202.05	156,870,202.05

Жаргалант сумын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2132	Бусад урсгал шилжүүлэг	41,230,013.00	31,606,100.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	9,623,913.00	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	28,019,100.00	28,019,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,587,000.00	3,587,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	22,876,064.76	22,876,064.76
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,876,064.76	22,876,064.76
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	880,154.55	880,154.55
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	880,154.55	880,154.55
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(123,694,144.88)	(123,694,144.88)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	73,688,567.83	73,688,567.83
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	73,688,567.83	73,688,567.83
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(73,688,567.83)	(73,688,567.83)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(197,382,712.71)	(197,382,712.71)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

АУДИТЛАГДАСАН					
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	595,526,061.12	1,566,236,273.72	1,110,640,138.30	3,272,402,473.14
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	595,526,061.12	1,566,236,273.72	1,110,640,138.30	3,272,402,473.14
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			7,710,927.86	7,710,927.86
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	595,526,061.12	1,566,236,273.72	1,118,351,066.16	3,280,113,401.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт		(7,710,927.86)		(7,710,927.86)
D08	Тайлант үеийн үр дүн			(197,382,712.71)	(197,382,712.71)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	595,526,061.12	1,558,525,345.86	920,968,353.45	3,075,019,760.43

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Жаргалант сумын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Аудитлагдаагүй	Аудитлагдсан
		Тайлант оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,154,694,367.55	1,154,694,367.55
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	17,402,454.55	17,402,454.55
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	700,000.00	700,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,329,254.55	16,329,254.55
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	373,200.00	373,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	176,077,700.00	176,077,700.00
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	176,077,700.00	176,077,700.00
1330	Төсвийн захирагчдаас	951,590,300.00	951,590,300.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	951,590,300.00	951,590,300.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	9,623,913.00	9,623,913.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	9,623,913.00	9,623,913.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,151,114,367.55	1,151,114,367.55
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,151,114,367.55	1,151,114,367.55
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	754,966,275.39	754,966,275.39
210101	Үндсэн цалин	478,174,223.42	478,174,223.42
210102	Нэмэгдэл	233,597,564.68	233,597,564.68
210104	Урамшуулал	43,194,487.29	43,194,487.29
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	97,240,603.15	97,240,603.15
210201	Тэтгэврийн даатгал	66,155,511.10	66,155,511.10
210202	Тэтгэмжийн даатгал	7,771,273.01	7,771,273.01
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,217,018.41	6,217,018.41
210204	Ажилгүйдлийн даатгал	1,554,254.60	1,554,254.60
210205	Эрүүл мэндийн даатгал	15,542,546.03	15,542,546.03
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	166,518,256.70	166,518,256.70
210301	Гэрэл, цахилгаан	9,752,633.95	9,752,633.95
210302	Түлш, халаалт	152,773,632.00	152,773,632.00
210303	Цэвэр, бохир ус	3,991,990.75	3,991,990.75
2104	Хангамж, бараа материалын зардал	15,874,400.00	15,874,400.00
210401	Бичиг хэрэг	2,050,300.00	2,050,300.00
210402	Тээвэр, шатахуун	6,163,000.00	6,163,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	236,900.00	236,900.00
210404	Ном, хэвлэл	3,028,000.00	3,028,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,367,500.00	1,367,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,028,700.00	3,028,700.00
2105	Нормативт зардал	32,611,000.00	32,611,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	756,400.00	756,400.00
210502	Хоол, хүнс	27,160,600.00	27,160,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,694,000.00	4,694,000.00

Жаргалант сумын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,151,900.00	2,151,900.00
210604	Урсгал засвар	2,151,900.00	2,151,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,700,000.00	2,700,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,700,000.00	2,700,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,074,500.00	10,074,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	700,000.00	700,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,374,500.00	9,374,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	40,921,213.00	40,921,213.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	9,623,913.00	9,623,913.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	27,710,300.00	27,710,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,587,000.00	3,587,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	22,876,064.76	22,876,064.76
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,876,064.76	22,876,064.76
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,180,154.55	5,180,154.55
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,180,154.55	5,180,154.55
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>3,580,000.00</u>	<u>3,580,000.00</u>
140005	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	3,580,000.00	3,580,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,580,000.00	3,580,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(3,580,000.00)</u>	<u>(3,580,000.00)</u>

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны / төгрөгөөр /	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,145,192,420.00	1,101,991,935.24
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,145,192,420.00	1,101,991,935.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,109,490,920.00	1,072,754,635.24
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	764,420,800.00	754,966,275.39
210101	Үндсэн цалин	458,689,600.00	478,174,223.42
210102	Нэмэгдэл	247,521,400.00	233,597,564.68
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,308,800.00	-
210104	Урамшуулал	55,901,000.00	43,194,487.29
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	102,793,100.00	97,240,603.15
210201	Тэтгэврийн даатгал	72,216,300.00	66,155,511.10
210202	Тэтгэмжийн даатгал	7,644,200.00	7,771,273.01
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,115,400.00	6,217,018.41
210204	Ажилгүйдлийн даатгал	1,528,800.00	1,554,254.60

Жаргалант сумын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210205	Эрүүл мэндийн даатгал	15,288,400.00	15,542,546.03
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	171,347,000.00	166,518,256.70
210301	Гэрэл, цахилгаан	7,333,300.00	9,752,633.95
210302	Түлш, халаалт	139,261,600.00	152,773,632.00
210303	Цэвэр, бохир ус	24,752,100.00	3,991,990.75
2104	Хангамж, бараа материалын зардал	18,083,700.00	11,641,800.00
210401	Бичиг хэрэг	2,050,300.00	371,300.00
210402	Тээвэр, шатахуун	6,163,800.00	5,966,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	236,900.00	236,900.00
210404	Ном, хэвлэл	5,236,500.00	1,277,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,367,500.00	1,007,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,028,700.00	2,783,100.00
2105	Нормативт зардал	33,389,420.00	31,961,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	756,400.00	376,400.00
210502	Хоол, хүнс	27,939,020.00	27,160,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,694,000.00	4,424,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,951,900.00	1,930,700.00
210604	Урсгал засвар	4,951,900.00	1,930,700.00
2107	Томилолт, зочны зардал	553,000.00	-
210702	Дотоод албан томилолт	553,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,854,000.00	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,854,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,098,000.00	8,496,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	700,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,398,000.00	8,496,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35,701,500.00	29,237,300.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	35,701,500.00	29,237,300.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	29,764,500.00	27,710,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,937,000.00	1,527,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,127,668,000.00	1,127,668,000.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	951,590,300.00	951,590,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	951,590,300.00	951,590,300.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	176,077,700.00	176,077,700.00
132001	Орон нутгийн төсвөөс	176,077,700.00	176,077,700.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	1.00
610001	Төсвийн байгууллага	-	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	-	65.00
620001	Удирдах ажилтан	-	4.00
620002	Гүйцэтгэх ажилтан	-	37.00
620003	Үйлчлэх ажилтан	-	24.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	-	550.00
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	-	550.00
630001	Төрийн өмчит ЕБС	-	550.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	-	61.00
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	-	37.00

Жаргалант сумын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	-	1.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	-	1.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	-	22.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	11,442,300.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	11,442,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,382,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,232,600.00
210401	Бичиг хэрэг	1,679,000.00
210402	Тээвэр, шатахуун	197,000.00
210404	Ном, хэвлэл	1,751,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	360,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	245,600.00
2105	Нормативт зардал	650,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	380,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	270,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	221,200.00
210604	Урсгал засвар	221,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,700,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,700,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,578,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	700,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	878,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,060,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,060,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,060,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	17,402,454.55
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	17,402,454.55
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	700,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,329,254.55
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	373,200.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Жаргалант сумын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх

санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Азжаргал гүйцэтгэж хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Жаргалант сумын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн 1/03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Жаргалант сумын дунд сургууль нь Ажлын байран дахь багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжин хосолмол сургалт, үйл ажиллагааны чанар үр дүнг дээшлүүлэх, эрүүл чийрэг зөв боловсон, сурах арга барил эзэмшсэн хүүхэд төлөвшүүлэх зорилго бүхий БШУЯамны харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын хууль тогтоомж, Нийгмийн даатгалын тухай хууль, ТБОНӨХБАҮХАТХууль тогтоомжид өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллагад дотоод аудитын нэгж, хариуцсан ажилтан ажилладаггүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Жаргалант сумын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлэн, төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв болох 1,145,192.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 11,451.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг өөрчлөөгүй бөгөөд 70 хувиар буюу 8,016.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад өөрчлөөгүй болно.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Жаргалант сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 200,095.1 мянган төгрөгөөр буюу 6.1 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Бараа материал	116,451.7	128,559.3	12,107.6
Үндсэн хөрөнгө	3,479,643.0	3,424,343.6	(55,229.4)
Авллага	11,294.0	4,300.0	(6,994.0)
Нийт хөрөнгө	3,275,114.9	3,075,019.8	(200,095.1)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,275,114.9	3,075,019.8	(200,095.1)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,275,114.9	3,075,019.8	(200,095.1)

Бараа материалын данс 128,559.3 мянган төгрөг болж 12,107.6 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал үлдэгдэлтэй гарснаас шалтгаалсан байна.

Энэ нь Ковид цар тахалтай холбоотой ариутгал цэвэрлэгээний материалыг тодорхой хэмжээний нөөц үүсгэсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,424,343.6 мянган төгрөг болж 55,229.4 мянган төгрөгөөр буурсан нь байгууллагын дансанд дотуур байр бүртгэлтэй орон сууцны байрыг Жаргалант сумын ЗДТГ-н балансад шилжүүлсэнтэй холбоотой.

Өөрийн хөрөнгөөр 3,580.0 мянган төгрөгийн, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 5,770.0 мянган төгрөгийн, ОНХСангийн хөрөнгө оруулалтаар 16,000.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгүүд бэлтгэгдэж ирсэн ба 80,649.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө шилжүүлсэн байна. Санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт орлого өмнөх оноос 1,386,549.0 мянган төгрөгөөр буюу 54.3 хувиар буурч, нийт зардал өмнөх оноос 114,706.6 мянган төгрөгөөр буюу 9.65 хувиар өссөн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Жаргалант сумын ерөнхий боловсролын сургууль нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 995,652.7 мянган төгрөгөөр төлөвлөн, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэнээс 1,127,668.0 мянган төгрөгөөр батлагдан ирсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлэхээр 951,590.3 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээр, орон нутгийн төсвөөс 176,077.7 мянган төгрөг, Малчдын хүүхдийг манлайлагч болгоё, хоцрогдолгүй сурагч хойчийн ирээдүй, төслийн санхүүжилт 17,402.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал зардалд нийт 1,145,070.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,145,070.4 мянган төгрөг буюу цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардалд 754,966.3 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлд 97,240.6 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 166,518.3 мянган төгрөг, хангамжийн материалын зардалд 15,874.4 мянган төгрөг, норматив зардал 32,611.0 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардал 5,151.9 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 2,700.0 мянган төгрөг, бусад бараа үйлчилгээний зардалд 10,074.5 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшуулалын зардалд 3,587.0 мянган төгрөг зарцуулсан ба хэмнэгдсэн зардал болох нийт 28,056.2 мянган төгрөгийг төрийн санд төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд малчдын хүүхдийг манлайлагч болгоё хоцрогдолгүй сурагч хойчийн ирээдүй, төслийн санхүүжилт 11,294.0 мянган төгрөгийн санхүүжилт авч төслийн заалт, зорилго, зорилтын дагуу зарцуулсан бөгөөд 4,300.0 мянган төгрөгийг төрийн санд төвлөрүүлж авлагаар тусгаж өгсөн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудит хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын

талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай. Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Жаргалант сумын сургууль нь 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 134 мэдээллийг байршуулж 15 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн зарлагын гүйлгээ хийхдээ цахим төлбөрийн е-баримтгүй, анхан шатны баримтын бүрдэлгүй, 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 134 мэдээллийг байршуулж 15 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна. Энэ Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 7.1-д "Төсвийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно", 7.6-д "Төсвийн жил эхлэхэд төсвийн захирагчийн тухайн төсвийн жилийн батлагдсан төсвийг зарцуулах эрх нь нээгдэнэ", 16.5.2-д "батлагдсан төсөв хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 42.2.2-д "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.7-д "хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй", Засгийн газрын 43 дугаар тогтоол "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай", Шилэн дансны тухай хуулийн 6.1-д энэ хуулийн 3.1.1, 3.1.2-д "заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" хүрээнд шалгасан зүйлийн холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн нийт 12,744.4 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 1 зөвлөмж бүрэн хэрэгжсэн байна.

Хүснэгт . Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Жаргалант сумын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	хувь
Зөвлөмж	1	2,712.4	1	2,712.4	0	0	0
Албан шаардлага	1	10,032.0	1	10,032.0	0	0	0
Нийт дүн	2	12,744.4	2	12,744.4	0	0	0

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 16,989.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 9,623.9 мянган төгрөгийн алдааг залруулж, 502.7 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 5,313.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 албан шаардлага, 1,549.4 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Зардлын зүйл ангийг буруу сонгосоноор санхүүгийн үр дүнгийн тайланд 9,623.9 мянган төгрөгийн зөрүүтэй илэрхийлсэнийг залруулав.

4.2 Төлбөрийн акт

1.1. Илрүүлэлт:

2020 оны хичээлийн жилийн үр чадварын нэмэгдэл болох 290.9 мянган төгрөгийг 3 багшид олгосон бөгөөд тухайн оны санхүүгийн тайландаа өглөгөөр тусгаагүй 2021 оны батлагдсан төсвөөс нөхөн олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 7.1-д "Төсвийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно", 7.6-д "Төсвийн жил эхлэхэд төсвийн захирагчийн тухайн төсвийн жилийн батлагдсан төсвийг зарцуулах эрх нь нээгдэнэ", 16.5.2-д "батлагдсан төсөв хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 42.2.2-д "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

1.2. Илрүүлэлт:

Сахилагын шийтгэлтэй ажилтанд 211.8 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.7-д "хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

4.3 Албан шаардлага

1.3. Илрүүлэлт:

Засгийн газрын тогтоол зөрчин нормын хувцас, биеийн тамир уралдаан тэмцээн, нэвтрүүлэг зохион байгуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.2-д "батлагдсан төсөв хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Засгийн газрын 43 дугаар тогтоолтой нийцэхгүй байна.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

2. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Зарлагын гүйлгээ хийхдээ анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй 1,549.4 мянган төгрөгийн дутуу баримтаар гүйлгээ хийсэн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.2-д "батлагдсан төсөв хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийн зарцуулалтад үр дүнтэй хяналт хэрэгжүүлж, эрх бүхий байгууллагаас гаргасан тогтоол, журмын хэрэгжилтийг хангуулах. Бараа материалын бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй баримтаар гүйлгээ хийхгүй байх.

2.3. Илрүүлэлт:

149 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 15 мэдээ мэдээллийг хугацаа хоцроож мэдээллэсэн. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6.1-д "энэ хуулийн 3.1.1, 3.1.2-д заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

2.4. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны мэдээллийг үр дүнтэй хяналт хэрэгжүүлж, эрх бүхий байгууллагаас гаргасан тогтоол, журмын хэрэгжилтийг хангуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Д/д	Аудитад хамрагдсан	Нийт алдаа, зөрчлийн	Үүнээс			
			Залруулга	Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж
/мянган төгрөгөөр/						

Жаргалант сумын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

	байгууллагын нэр	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Жаргалант сумын сургууль	6	16,989.0	1	9,623.9	2	502.7	1	5,313.0	2	1,549.4